



**ХЭНТИЙ АЙМАГ  
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг  
Утас: 70-56-21-01

2022.04.19 № 12  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн 2021 оны нөхөн сонгуульд Хэнтий аймгийн Монгол Ардын намын хороо нь 2020 оны мөрийн хөтөлбөрөөр оролцоно. Тус мөрийн хөтөлбөрийн эдийн засгийн тооцоолол, баримт бичигт өөрчлөлт ороогүй болно.

ДЭД ДАРГА



Б.ЭНХ-ЭРДЭНЭ



## АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ХЭНТИЙ АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЬМӨРИЙН ХӨТӨЛБӨР

### НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

#### 1.1. Орлоготой иргэн

- 1.1.1. Өрхийн бичил бизнесийг дэмжиж, иргэдэд хүүгүй, барьцаагүй санхүүгийн дэмжлэг үзүүлэх бодлогыг үргэлжлүүлнэ.
- 1.1.2. Гарааны бизнес эрхлэгч оюутан, залууст бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, мэдлэг, ур чадвар олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 1.1.3. Орлого багатай өрхийн ажил эрхлээгүй насанд хүрсэн гишүүдийг бүртгэлжүүлж, мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- 1.1.4. Хуримтлалын аяныг аймгийн хэмжээнд жил бүр өрнүүлнэ.
- 1.1.5. Хэнтий аймагт хийгдсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бодлогоор дэмжиж, тэгш гараанаас бизнес эрхлэх нөхцлийг бий болгоно.
- 1.1.6. Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг бизнес инкубацын үйлчилгээгээр бойжуулж, томруулах бодлогыг үргэлжлүүлж, хамгийн бага түрээс төлөх зохицуулалт хийнэ.
- 1.1.7. Иргэдийн туршлага, ур чадвартаа түшиглэн хийж байгаа бизнесийг дэмжиж, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, төхөөрөмж авах хөнгөлөлттэй зээл олгоно.

#### 1.2. Хуримтлалын нэгдсэн сан ба орон сууцтай өрх

- 1.2.1. Анх удаа орон сууцны зээл авч байгаа нийгмийн даатгалын шимтгэл төлдөг иргэдэд урьдчилгаагүй, бага хүүтэй зээлийн хөтөлбөрт хамрагдах, анх удаа байр авч байгаа бага, дунд орлоготой иргэдэд 4-6 хувийн хүүтэй орон сууцны ипотекийн зээл олгох Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлж ажиллана.
- 1.2.2. Орон сууц худалдан авах ипотекийн зээлийн хүртээмж, хамрах хүрээг өргөтгөнө.
- 1.2.3. Орон сууцны төлөвлөлтөд сургууль, цэцэрлэг, ногоон байгууламж, усан сан, биений тамирын талбай бүхий тохилог орчин бүрдүүлэх стандарт хэрэгжүүлнэ.
- 1.2.4. Хүн бүрийг хөдөлмөрийн цахим бүртгэлтэй болгож, нийгмийн даатгал, хамгааллын тогтолцоотой уялдуулж, хөдөлмөр эрхлэлтийн хариуцлагыг нэмэгдүүлнэ.
- 1.2.5. Иргэн бүрд суурь тэтгэвэр олгох, хувийн даатгалын үйлчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлнэ.

#### 1.3. Эрүүл иргэн

- 1.3.1. Иргэн бүрийг эрүүл мэндийн оношилгоонд жил бүр хамруулна.
- 1.3.2. Эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээ, эмийн хөнгөлөлт авах зэрэг цахим эрүүл мэндийн системийг бүрэн нэвтрүүлж, эмчлүүлэгчийн нууцлалыг хангаж, зардал, хүлээгдэл, чирэгдлийг бууруулна.

1.3.3.Хавдар, зүрх судасны өвчлөлийг эрт илрүүлэх бололцоог хангаж, гадаад улсад оношилгоо, эмчилгээ хийлгэх иргэдийн урсгалыг эрс бууруулна.

1.3.4. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумдын эрүүл мэндийн төвийн удирдлага, менежментийг улс төрөөс ангид байлгаж, чадварлаг хүний нөөц, хамт олны дэмжлэгт тулгуурлан томилно.

1.3.5.“Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг аймагтаа үргэлжлүүлж, “Хавдрын эсрэг хамтдаа” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.

1.3.6.Хелико бактеритай тэмцэх, хянах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж нянгийн шалтгаант ходоодны архаг үрэвсэл, шарх, хорт хавдрын шинэ тархалтыг таслан зогсооно.

1.3.7.“Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” хөтөлбөрийг үргэлжлүүлэх дэд хөтөлбөрийг боловсруулан баталж,хүүхдийн хоолойн архаг (ангина) өвчнийг эрт илрүүлэн эмчлэх, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдэлээс бага насанд нь сэргийлэх “Эрүүл ирээдүй” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.3.8.Яаралтай тусламжийн чанарыг дээшлүүлж, түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлтийг бүрэн хийнэ.

1.3.9.Эрүүл мэндийн салбар, эмнэлгийн албан хаагчдын ажиллах орчныг сайжруулан, аймгийн нэгдсэн эмнэлэг, сумын ЭМТ-ийг сувилагч, асрагчаар бүрэн хангана.

1.3.10.Зарим сумын ЭМТ-ийн барилгыг шинээр болон өргөтгөлийг барьж, халуун, хүйтэн ус, ариун цэврийн байгууламжтай болгоно.

1.3.11.Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах “Цахим карт” олгоно.

1.3.12. “Идэвхтэй эрүүл амьдрал” хөтөлбөрийг хэрэгжүүлж, дасгал хөдөлгөөн, зөв хооллолт, стресс бухимдлаас ангид байх эрүүл амьдралын дадал хэвшлийг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлнэ.

1.3.13.Унадаг дугуй унах, гүйх, дасгал хөдөлгөөн хийх, бие бялдраа хөгжүүлэх, эрүүл хооллолт зэрэг эрүүл байхад чиглэсэн хөдөлгөөн, санаачилгыг бодлогоор дэмжинэ.

1.3.14.Өрхийн эмнэлгийн статусыг тодорхой болгож, санхүүжилтийг оновчтой хэлбэрээр шийдвэрлэнэ.

#### **1.4.Чанартай боловсрол, шинжлэх ухаан, инновацын хөгжил**

1.4.1.Ерөнхий Боловсролын Сургууль, цэцэрлэгийн багш, ажилтны нийгмийн болон хөдөлмөрийн үнэлэмжийг үнэлэх аймгийн бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.

1.4.2.Аймагт хувийн дунд сургууль байгуулах санаачлагыг дэмжинэ.

1.4.3.Багш нарын мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, мэргэжил дээшлүүлэх гадаад, дотоодын сургалт, үйл ажиллагаанд хамруулж, “Чадварлаг багш” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, багш нарыг урамшуулах тогтолцоог бий болгоно.

1.4.4.Боловсролын салбарыг улс төрөөс ангид байлгаж, сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг мэдлэг чадвар, ажлын гүйцэтгэл, туршлагад нь үндэслэн сонгон шалгаруулж томилно.

1.4.5.Цэцэрлэгийн хүүхдийн орны тоог эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн шинэ цэцэрлэгийг нэмж барина.

1.4.6.Аймгийн Яслийн үйлчилгээ, хамрах хүрээг нэмэгдүүлж, зарим томоохон сум, суурин газарт шинээр бий болгоно.



Handwritten red text: "Хүндэтгэсэн" (Certified)

Handwritten red text: "231 СЮА0"

1.4.7.“Үдийн хоол” хөтөлбөрийг үргэлжлүүлж, хүүхдэд шим тэжээл, амин дэмээр баялаг хоолоор үйлчилнэ.

1.4.8.Сэтгэл зүйч-мэргэжилтнийг сургууль бүрд ажиллуулна.

1.4.9.Тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй хүүхэд ердийн сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих орчин бүрдүүлнэ.

1.4.10.Аймгийн лаборатори 1 дүгээр сургууль, Жаргалтхаан, Өмнөдэлгэр сумын ЕБС-ийн барилга, Батноров сумын сургуулийн өргөтгөлийг ашиглалтад оруулж, Хэрлэн суманд 5 дугаар сургуулийг байгуулна.

1.4.11.Спортын дагнасан сургууль байгуулах санаачлагыг дэмжинэ.

1.4.12.Бэрх хотод олон улсын хөтөлбөртэй чанарын шаардлага хангасан жишиг сургуулийг барьж дуусгана.

1.4.13.Сургуулиуд өндөр өнжүүлэх анги, бүлэг хичээллүүлэхийг дэмжинэ.

1.4.14.Сурагчдын сонирхол, авьяас чадварыг нээн хөгжүүлэх, сонгон, секц, дугуйлангийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.

1.4.15.Сургуулийн дотуур байр, ногоон хөгжлийн байгууламж, спортын болон урлагийн заал, цайны газар, мэдээлэл зүйн сургалтын танхимыг тохижуулж, тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй суралцагчдад зориулсан тохируулгат орчин бүрдүүлнэ.

1.4.16.Нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн өрөөтэй болгох ажлыг шат дараатай хийж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.

1.4.17.Боловсролын зээлийн сангийн хүртээмжийг нэмэгдүүлэх Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлж, оюутан ар гэртээ санхүүгийн дарамтгүйгээр суралцах нөхцлийг бүрдүүлнэ.

1.4.18.Сургалтын хөтөлбөрийн тэтгэлэг олгох “Үндэсний тэтгэлэгт хөтөлбөр”-ийг орон нутагтаа хэрэгжүүлнэ.

1.4.19.Политехник коллежийн сургалт, үйлдвэрлэлийн чанар, стандарт, өрөө, тасалгаа, барилгын ашиглалт, сургалтын чанарыг сайжруулна.

1.4.20.Бүх насны суралцагч, иргэдэд зориулсан онлайн сургалтын хөтөлбөр боловсруулан түгээж, хүн бүр орон зай, цаг хугацаанаас үл хамааран өөрийн хүссэн чиглэлээр насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлнэ.

1.4.21.Олон улсын түвшинд зохион байгуулагдаж буй олимпиад, уралдаан, тэмцээнд оролцож, амжилт үзүүлсэн суралцагч, багш, судлаач, багийг дэмжиж урамшуулна.

1.4.22.Ном унших, номын сан, өргөөг олон нийтэд хүртээмжтэйгээр байгуулах түүгээр үйлчлэх санал санаачилгыг дэмжих, ном уншсан хүүхэд иргэдийг урамшуулах, гадаад, дотоодод аялуулж, ном унших хөдөлгөөнийг өргөжүүлнэ.

## 1.5.Тогтвортой-амар, амгалан гэр бүл

1.5.1.Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох аргачлалд тулгуурлан хүнсний талон зэрэг нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлнэ.

1.5.2.Орлого багатай өрхийн нийгмийн хамгаалал, амьжиргааг дээшлүүлэх олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг нэвтрүүлнэ.

1.5.3.Угийн бичгээ хөтлөх, цус ойртолтоос урьдчилан сэргийлэх, удмын сангаа хамгаалах ажлыг зохион байгуулна.

1.5.4.Гэр бүл, өрхийн хөгжлийг дэмжих аймгийн дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.



## **1.6. Хүүхэд хамгаалал, хөгжил**

1.6.1. Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, нийгмийн төлөвшилтийг дэмжихэд эцэг, эхчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.

1.6.2. Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж, хүүхэд олноор зорчих хэсгийг гарц, гэрлэн дохио, хурд сааруулагч, камертай болгоно.

1.6.3. Хүүхдийн тоглоомын талбай, орчны стандартыг мөрдүүлж, хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлж, хяналтыг сайжруулна.

1.6.4. Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх төвийн байрыг эрсдэл өндөртэй сум суурин газарт байгуулна.

1.6.5. Орон сууцны хороолол, 4-6 байрны дунд тоглоомын стандартад нийцсэн талбай бий болгоно.

1.6.6. Аймагтаа хүүхдийн зуслан байгуулна.

## **1.7. Хан Хэнтийн Залуучуудын хөгжил**

1.7.1. Залуучууд, залуу гэр бүлийг орлогод нь нийцсэн, уян хатан төлбөрийн нөхцөлтэй орон сууц худалдан авахад дэмжлэг үзүүлнэ.

1.7.2. Залуучуудын хөгжлийг дэмжих аймгийн сан байгуулж, дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

1.7.3. Гэр бүл, хүүхэд, оюутан, залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх орчин бий болгоход зориулсан төвийг шинээр байгуулна.

1.7.4. Хүүхэд, оюутан, залуучууд, өсвөр үеийнхнийг гадны сөрөг нөлөө, бусдын дарамт, гэмт хэрэгт өртөх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэхээс сэргийлэх, цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.7.5. Залуу гэр бүлийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжсэн "Залуу гэр бүл" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.7.6. Хүн амын өсөлтийн бодлогын хүрээнд гурав ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлд хүүхдийн тооноос хамаарсан татварын хөнгөлөлт үзүүлэх "Тогтвортой-амар амгалан гэр бүл" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.

## **1.8. Тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэдээ дэмжих**

1.8.1. Тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэдийн эрх, оролцоог хангаж, нөхөн сэргээх эмчилгээ, сувилгаа болон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

1.8.2. Тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэд хэрэгцээт үйлчилгээгээ авах нөхцлийг төрийн болон бусад бүх байгууллагад бүрдүүлнэ.

1.8.3. Тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй 0-16 насны хүүхдээ асран ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа эх (эцэг)-ийн нийгмийн даатгалын шимтгэлийг төрөөс төлөх боломжийг орон нутагтаа хэрэгжүүлнэ.

1.8.4. Байнгын асаргаа шаардлагатай тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэд, ахмадуудад зориулсан төрөлжсөн асрамж, сувиллын үйлчилгээний тогтолцоог сайжруулна.

## **1.9. Ахмадуудад үзүүлэх үйлчилгээ**

1.9.1. Ахмадын хөгжлийн аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.9.2. Ахмад настны орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх ажил эрхлэлт, зөвлөх үйлчилгээг үр дүнтэй хэлбэрээр үргэлжлүүлнэ.

1.9.3. Ахмад настны чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрүүлэх, мэдээлэл авах, хөгжих боломжийг бүрдүүлэх хөгжлийн төвүүдийн үйл ажиллагааг тогтмолжуулна.



1.9.4.Аймгийн ахмадын хөгжлийн сан байгуулна.

### 1.10.Үндэсний бахархал, өв соёл, спорт

1.10.1.Хэнтий аймгийн онцлог, соёл иргэншил, үнэт зүйлийг танилцуулсан өв, соёл, урлаг, аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

1.10.2.Соёл, урлаг, оюуны болон спортын төрлөөр дэлхий, олон улс, Монгол улсад танигдсан Хэнтийн брэндийг дэмжиж, Хэнтийн бахархлыг төлөвшүүлнэ.

1.10.3.Хэнтий аймгаас төрөн гарсан алдартнуудын амьдрал, гавьяа зүтгэлийг бүтээлийг сурталчилсан Хэнтий аймгийн түүхийн ном товхимолыг шинээр гаргана.

1.10.4.“Хан Хэнтий” чуулгыг ардын урлагийн театр болгон хөгжүүлж, дэргэдээ аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох боломжийг бүрдүүлнэ.

1.10.5.Монгол улсын гал голомт аймаг болохын хувьд “Монгол бичгээ сурах, сурталчлах хөдөлгөөн”-ийг нийт иргэд, өргөн түмнийг хамруулан улсын хэмжээнд жишиг, туршлага болохуйцаар төлөвлөн далайцтай, ач холбогдол өгч өрнүүлнэ.

1.10.6.Олон улсын наадам, уншигч-зохиолчдын уулзалт, яруу найргийн баяр /Болор цом/-ыг орон нутагтаа хүлээн авч зохион байгуулж, Р.Чойномын нэрэмжит “Оюухай” яруу найргийн наадмыг аймаг ивээлдээ авч 3 жил тутам хийж байна.

1.10.7.Түүх, соёлын өвийг сүйтгэж байгаа хууль бус үйл ажиллагаатай хатуу тэмцэж, хариуцлагыг чангатгаж, биет болон биет бус өвийг хамгаална.

1.10.8.Иргэд идэвхтэй хөдөлгөөн хийх, уулын болон явган аялал, дугуйн спорт зэрэг нийтийн биеийн тамирын төрлүүдийг дэмжиж, хамрах хүрээг өргөжүүлнэ.

1.10.9.Аймгийн Музейг барьж ашиглалтад оруулж, үзмэрийг шинээр дэглэнэ.

1.10.10.Магадлан итгэмжлэгдсэн спортын клубд хамрагдаж буй төлбөр тооцоог эрүүл мэндийн даатгалаар төлдөг болгож, спортоор хичээллэдэг иргэдийн тоог нэмэгдүүлнэ.

1.10.11.“Олимп” цогцолборыг хувийн хэвшилд гэрээний хэлбэрээр шилжүүлж, үйл ажиллагааг тогтмолжуулна.

1.10.12.Чингис хотод усан спорт сургалтын төв шинээр барина.

1.10.13.Норовлин сумын Соёлын төвийн барилгыг барьж дуусгах, Галшар, Цэнхэрмандал, Мөрөн, Батширээт суманд Соёлын төв шинээр барина.

## ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

### 2.1.Хөгжилд хөтлөх мега төслүүд

2.1.1.Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэр, үйлдвэрийн орчинд байгаа томоохон үйлдвэрүүдийн эдийн засгийн хүртээмж, ашиглалт, орон нутгийн хөгжилд оруулах боломж, чадавхийг нэмэгдүүлнэ.

2.1.2.Бичил уурхайн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, орон нутгийн хөгжилд оруулах нөлөө, үр өгөөжийг нэмэгдүүлж, хариуцлагын тогтолцоог бий болгоно.

### 2.2.Эдийн засгийн төрөлжилт

#### 2.2.1.ХАА-н чиглэлээр

2.2.1.Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангах бодлогыг орон нутгийн түвшинд тууштай хэрэгжүүлнэ.

2.2.2.Аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, ажлын байр шинээр бий болгоно.

2.2.3.Экспортын мах, махны үнийг нэмэгдүүлэх, малчдын орлогыг нэмэгдүүлэх бүхий л боломжийг судлан хэрэгжүүлнэ.

2.2.4.Малчин, тариаланчдын нийгмийн асуудлыг шийдэх дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.



2.2.5.Хөдөө аж ахуйн салбарт малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх “Илгээлтийн эзэн – III” аяныг аймагтаа хэрэгжүүлнэ.

2.2.6.Мал, амьтны гаралтай арьс, шир, үс, ноос, ноолуурыг бүрэн боловсруулж, оёмол, сүлжмэл бэлэн бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлэхэд аймгийн иргэд, малчдыг татан оролцуулна.

2.2.7.“Ноолуур” дэд хөтөлбөр хэрэгжүүлж, малчдын орлогыг тогтвортой байлгахад дэмжлэг үзүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

2.2.8. “Монгол мал-2” хөтөлбөрийг хэрэгжүүлж, малыг эрүүлжүүлэх, чанар, ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлж, малын тоог чанарт шилжүүлж ашиг шим, хүртээмжийг сайжруулах, малын генийн санг хамгаална.

2.2.9.Малыг ялган тэмдэглэх, малыг им тамга, тэмдэг, зүсмийн бүртгэлд бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлж, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сантай болно.

2.2.10.Мал эмнэлгүүдийг дэмжиж, малын эмч, зоо-техникчдийг тэтгэлэгт хөтөлбөрөөр бэлтгэн, хөдөө орон нутагт ажиллуулна.

2.2.11.Халдварт өвчинтэй тэмцэх, мал сүргийг бүрэн вакцинжуулах дунд хугацааны стратегийг хэрэгжүүлж, гоц халдварт өвчингүй, тайван бүсийг баталгаажуулна.

2.2.12.Сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, дотоодын сүүний үйлдвэрлэл, боловсруулалтыг өсгөж, сүүтээ борлуулж буй малчдыг дэмжинэ.

2.2.13.Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир, ноос, ноолуур, түүхий эд бэлтгэн тушаасан малчин, мал бүхий этгээдэд түүхий эдийн чанартай нь уялдуулан мөнгөн урамшуулал олгох тогтолцоог улам сайжруулна.

2.2.14.“Атар-4” аяныг орон нутагтаа хэрэгжүүлж, тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

2.2.15.Хүлэмж, агуулахын аж ахуйг хөгжүүлэх замаар байцаа, манжин, лууван, сонгино, сармис зэрэг хүнсний ногоогоор аймгийн хэрэгцээг бүрэн хангана.

2.2.16.Царгас зэрэг тэжээлийн ургамал тариалах санаачлагыг дэмжинэ.

2.2.17.Газар тариалангийн бүс нутагт усжуулалтыг нэмэгдүүлж, үрийн шилмэл сортын нөөц бүрдүүлнэ.

2.2.18.Төмс хүнсний ногооны худалдан борлуулах төрөлжсөн худалдааны цэгийг ногоочдын үүсгэл санаачилгад тулгуурлан Чингис хотын төвд байгуулах ажилд дэмжлэг үзүүлнэ.

2.2.19.Хүнсний ногооны борлуулалтыг төрийн худалдан авалт /боловсрол, эрүүл мэнд, батлан хамгаалах, хууль сахиулах болон уул уурхай / -аар дэмжих бодлого, зохицуулалтын арга хэмжээ авна

2.2.20.Зоорийн аж ахуйг нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрийг дэмжиж, 30 тн-оос дээш багтаамжтай зорь барьсан иргэдэд урамшуулал олгоно.

2.2.21.Хоршоологч, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид, тариаланч ногоочдын зөвлөгөөнийг тогтмолжуулна.

### 2.3.Төрөлжсөн аялал жуулчлал

2.3.1.Аялал жуулчлалын салбарын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгон үндэсний онцлог, ялгарал бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдийг түшиглэсэн тогтвортой эко аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

2.3.2.Аялал жуулчлалын гадаад, дотоодын хамтын ажиллагаа, олон улс, дотоодын сурталчилгаа, маркетингийн ажлыг эрчимжүүлж, цар хүрээг гадаад, дотоодын жуулчдын тоо, хэмжээг нэмэгдүүлнэ.



2.3.3. Аялал жуулчлалын үйлчилгээний чанар, эрүүл ахуйн шаардлагыг сайжруулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

2.3.4. Аялал жуулчлалын гол чиглэлийн авто зам дагуу түр буудаллах үйлчилгээний цогцолбор байгуулна.

2.3.5. Техник, технологийн коллежд Аялал жуулчлалын мэргэжлийн анги нээнэ.

2.3.6. Баян-Адрага сумын Баян дуурлигийн нарсан ой, Хүннүгийн дурсгалыг түшиглэн аялал жуулчлалын төв, “Алсыг харагч” байгуулна.

2.3.7. “Мянганы суут хүн-Их эзэн Чингис хаан” Түүхэн аялал жуулчлалын үндэсний парк төслийн хүрээнд “Чингис хаан” - Дадал сум, “Их Хуралдай” - Биндэр сум, “Хүлэг Боорчи-Андлалын өргөө” - Батноров сум, “Шихихутаг-Их засаг” - Норовлин сум, “Монголын далд уурхайн музей, сургалт, судалгаа, аялал жуулчлалын төв” – Бэрх хот, “Монголын нууц товчоо” Дэлгэрхаан сум, цогцолборууд, аялал жуулчлалын батлагдсан маршрутын дагуу “Мэдээлэл, үйлчилгээний жишиг төв”-үүдийг барьж дуусган эдийн засгийн эргэлтэд оруулна.

2.3.8. Чингисийн есөн өрлөг баатрын нэг “Зургаадай” хэмээх Зөв жанжиныг Хэнтийн хүнээр зарлах, түүхэн гавъяа, зүтгэлийг нь алдаршуулах, мөнхжүүлнэ.

2.3.9. Түүх, соёлын үнэт өв болон байгалийн цогцолборт газруудаар аялал жуулчлалын “ЭКО АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ” хөтөлбөрийг боловсруулж, бүс нутаг, олон улсын хэмжээнд таниулан сурталчлах ажлыг зохион байгуулна.

2.3.10. Аялал жуулчлалын хөгжүүлэх бүсүүдэд дотоод гадаадын жуулчдыг хүлээн авах стандартын шаардлагад нийцсэн зочид буудал, жуулчдын бааз барих санаачлагыг дэмжинэ.

2.3.11. Нутаг орноо сурталчлан таниулах ажлыг дэмжиж, иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн бичил худалдаа, үйлчилгээ үзүүлэх боломжоор хангана.

2.3.12. “ХЭНТИЙН БРЕНД” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлж, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэн шошгожуулна.

## 2.4. Үндэсний дэд бүтцийн сүлжээ

### 2.4.1. Эрчим хүчний төсөл

2.4.1.1. Эрчим хүчний салбарын үр ашгийг нэмэгдүүлэн иргэд, айл өрхөд үнэ өртгийн дарамт бага байлгах бодлого баримталсан зах зээлийн зөв тогтолцоонд шилжүүлнэ.

2.4.1.2. Иргэдэд хэрэглээгээ хянадаг, гомдол саналаа шуурхай барагдуулдаг цахим хэрэглээний программ бий болгоно.

2.4.1.3. Багануур–Чингис–Чойбалсан 220кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барина.

2.4.1.4. Орон нутагт нарны эрчим хүчийг дулааны эх үүсвэр болгон ашиглах технологи нэвтрүүлнэ.

2.4.1.5. Баянхутагийн нүүрсний уурхайг шахмал түлшний үйлдвэр барих хувийн хэвшлийн санаачлагыг дэмжиж, аймгийн төвийн агаарын бохирдлыг бууруулна.

2.4.1.6. Хэрлэн сумын шинэ суурьшлын бүсэд цахилгаан дамжуулах шугам татна.

2.4.1.7. Цахилгаан дамжуулах ашиглалтын шугамын тулгуурыг бетонон тулгууртай болгоно.

## 2.5. Агаарын тээвэр

2.5.1. Аймгийн “Өндөрхаан” нисэх буудлыг олон улсын 4С зэрэглэл бүхий зорчигч үйлчилгээний цогцолбор болгож, “Дэлүүн болдог” /Дадал сум/ нисэх буудлуудын аэродром, барилга байгууламжийг барьж дуусгана.

## 2.6. Авто зам





2.6.1.Жаргалтхаан, Батширээт, Хурх, Биндэр, Баян-Адрага чиглэлийн дагуу Жаргалтхаан, Өмнөдэлгэр, Хурх, Биндэр чиглэлийн замын ажлыг эхлүүлнэ.

2.6.2. Даланжаргалан, Бор-Өндөрийн 45 км замыг дуусгана.

2.6.3.Аймгийн төв, Бэрх, Батноров, Норовлин, Дадал чиглэлийн 270 км замын ажлыг үргэлжлүүлнэ.

2.6.4.Сум бүрт 1 км хүртэлх стандарт шаардлагад нийцсэн гэрэлтүүлэг, явган, дугуйн зам бүхий зам барих ажлыг үе шаттай эхлүүлнэ.

2.6.5.Аймгийн төвд Унадаг дугуйн стандартад нийцсэн нийт 10 км зам байгуулна.

2.6.6.Аймгийн төвийн хатуу хучилттай автозамыг нэмэгдүүлж, хотын замыг засварлана.

2.6.7.Биндэр сумын Онон голын гүүрийг ашиглалтад оруулж, сумдад шаардлагатай гүүрийг засварлах, шинээр барих асуудлыг үе шаттай шийдвэрлэнэ.

## **2.7.Орон сууц**

2.7.1.Олон төрлийн /орлогод нийцсэн, түрээсийн, ногоон/ орон сууцны хангамжийг аймгийн хэмжээнд нэмэгдүүлж, инженерийн хангамжтай 2000 айлыг орон сууцаар хангах ажлыг эхлүүлнэ.

Үүнд: Сум суурин газрын гэр хорооллын газрыг дахин барилгажуулах төсөл-1000

Зөвшөөрөл олгогдсон барилгажилт төсөл- 700

Шинэ суурьшлын бүс хөгжүүлэх төсөл-100

Түрээсийн орон сууц- 200

## **2.8.Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа**

2.8.1.Баялаг бүтээгч, хувийн хэвшлийг дэмжсэн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.8.2.Шинээр ажлын байр нэмэгдүүлсэн иргэд, аж ахуйн нэгжийг татварын хөнгөлөлт, урамшууллын бодлогоор дэмжинэ.

2.8.3.Импортыг орлох бараа, бүтээгдэхүүнийг дотоодод үйлдвэрлэдэг баялаг бүтээгчдийг төрийн худалдан авалтаар дэмжинэ.

2.8.4.Нутаг орноо сурталчлан таниулах ажлыг дэмжиж, иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн бичил худалдаа, үйлчилгээ үзүүлэх боломжоор хангана.

2.8.5.“ХЭНТИЙН БРЕНД” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлж, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэн шошгожуулна.

## **ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО**

### **3.1.Шударга ёсны засаглал**

3.1.1. Төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, нэгтгэх замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.

3.1.2.Сонгуулийн үр дүнд томилогдсон, сонгогдсон албан тушаалтнуудтай хариуцлагын гэрээ, батламж байгуулж, алдаа гаргасан, нийтийн язгуур эрх ашгийг хохироосон бол хуулийн болон ёс зүйн хариуцлагыг тооцож ажиллана.

3.1.3. Чингис хааны нэрийг хууль тогтоомжоор хамгаалах, архи дарс эд зүйл нэрлэхгүй байх чиглэлээр төрийн төв байгууллагад санал хүргүүлж шийдвэрлүүлнэ.

3.1.4. Аймгийн хурлын шийдвэрээр албан бусаар нэрлэгдсэн, хуулийн хүрээнд улс батлаагүй байгаа Чингис хот гэж өөрчилсөн Өндөрхаан хот нэрийг хэрхэх тухай



саналыг гаргаж, Улсын Их Хурал, Засгийн газрын түвшинд нэг мөр шийдвэрлүүлнэ.

- 3.1.5. Төрийн захиргаа, удирдлага, хөгжил, шаардлагатай мэргэжлийн чиглэлээр жил бүр 10 хүртэл оюутныг гадаад, дотоодын их сургуульд бэлтгэж, хүний нөөцөө бүрдүүлнэ.

### 3.2. Цахим Хэнтий-шуурхай төрийн үйлчилгээ

- 3.2.1. Төрийн байгууллагад байгаа мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг бүрэн халж, иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг “Нэг иргэн- Нэг бүртгэл” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.2.2. Мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан төрийн байгууллагын үйлчилгээнд цахим технологи нэвтрүүлж, хүнд суртал, авлига хамгийн их үүсгэж буй үйлчилгээнүүдийг цахимжуулна.
- 3.2.3. Хүнд сурталгүй төрийн үйлчилгээ нэвтрүүлэх зорилгоор төрийн байгууллагуудын үйлчилгээг сайжруулж, төрийн албан хаагчдыг чадавхжуулж, төсвийн зардлыг хэмнэнэ.
- 3.2.4. Төрийн байгууллагын эд хөрөнгийн ашиглалт, бүртгэл, хамгаалалтын байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, холбогдох арга хэмжээ, хариуцлага тооцож ажиллана.
- 3.2.5. Төрийн албан хаагчдын интернет орчин /фэйсбүүк, социал/-д ажиллах цагийг хязгаарлах, ажлын цагт социал сүлжээнд орохгүй болгоно.
- 3.2.6. Төрийн бодлого, дүрэм, журам боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэд саналаа өгөх, хяналт тавих цахимаар оролцох боломжийг өргөжүүлнэ.
- 3.2.7. Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, хүсэлтийг шуурхай шийдэж, тушаал, шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг цахим хэлбэрээр хянадаг болно.
- 3.2.8. Орон нутгийн хөгжлийн сан, бусад нийтийн эрх ашигт үйлчилдэг сангийн үйл ажиллагааг иргэд, хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжихэд чиглүүлэн, олон нийтэд нээлттэй, хяналттай тогтолцоонд бүрэн шилжүүлнэ.

### 3.3. Мэргэшсэн, ёс зүйтэй төрийн алба

- 3.3.1. Архи согтууруулах ундаа хэрэглэх байдлыг төрийн аль ч шатны байгууллагад таслан зогсоох, архигүй орчин бүрдүүлэх, ажлын цаг, албан томилолттой үед архи уусан албан хаагчийг төрийн албанаас чөлөөлөх асуудлыг аймгийн хэмжээнд зарлана.
- 3.3.2. Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй байх, явцуу сонирхол, намын харьяаллаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг бүрэн хэвшүүлнэ.
- 3.3.3. Төр, иргэний нийгэм болон бизнесийн байгууллагад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх хандлага төлөвшүүлж, авлига, албан тушаалын гэмт хэргийн талаарх мэдээллийг урамшуулах эдийн засгийн болон бусад хөшүүргийг бий болгоно.
- 3.3.4. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.
- 3.3.5. Төрийн албанд шинээр томилогдсон иргэнийг орон нутаг, төрийн албаны анхан шатны нэгжид ажиллуулан дадлагажуулах замаар мэдлэг чадвар, туршлагыг нэмэгдүүлнэ.
- 3.3.6. Төрийн албан хаагчдыг тасралтгүй сургаж хөгжүүлэх цахим сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, хандлагыг эрс шинэчилнэ.



3.3.7. Төрийн жинхэнэ албан хаагч сонгуулийн үр дүнгээс үл хамааран чадахуйн болон шатлан дэвших зарчмын дагуу төрийн албанд тогтвортой ажиллах нөхцөлийг бодитоор хэрэгжүүлнэ.

#### 3.4. Ардчилсан, хүний эрхийг дээдлэх

3.4.1. Төрийн байгууллага, эдийн засаг, нийгэм, соёлын хүрээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, бүх түвшинд жендэрийн мэдрэмжтэй бодлого хэрэгжүүлнэ.

3.4.2. Аймгийн төвийн гудамж талбайг камержуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлыг эрчимжүүлнэ.

3.4.3. Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж, орон нутгийн авто замын хөдөлгөөнийг аюулгүй байдлыг хангах хяналтыг сайжруулна.

3.4.4. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэдийг хамгаалах төрөлжсөн түр хамгаалах байр, мэдээлэл, зөвлөгөө өгөх төвийг байгуулна.

3.4.5. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, Хэрэглэгч хаан дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.

#### ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

##### 4.1. Баталгаат ундны ус

4.1.1. Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийг аймаг, улсын тусгай хамгаалалтад авах саналыг гаргана.

4.1.2. Сум суурин газар ялангуяа Хэрлэн сумын ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг шинэчлэн өргөтгөж, баталгаат ундны усаар хангагдсан хүн амын тоог нэмэгдүүлнэ.

4.1.3. Хиймэл нуур, цөөрөм, хөв байгуулах, гадаргын ус ашиглах санаачилгыг дэмжинэ.

##### 4.2. Хариуцлагатай уул уурхай

4.2.1. Уул уурхайн лиценз олголтыг аймгийн хэмжээнд бүрэн зогсоож, мэдээллийг олон нийтэд нээлттэй болгож, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгоно.

4.2.2. Бичил уурхайтай холбоотой асуудлыг цэгцэлж, зөвшөөрөл олгох явцыг олон нийтийн хяналтын дор зохион байгуулдаг болгоно.

##### 4.3. Хүрээлэн буй орчин, уур амьсгалын өөрчлөлт

4.3.1. Тусгай хамгаалалттай газар, хамгаалалтад авах газар нутгийн хэмжээг нэмэгдүүлнэ.

4.3.2. Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах, цөлжилттэй тэмцэх аймгийн дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.

4.3.3. Суурин газрын ногоон байгууламжууд, зүлэгжилтийг стандарт шаардлагад нийцүүлэн, хогийн ургамлаас салах, ургаа модыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр эрүүлжүүлэх, модыг загвар оруулж хэлбэржүүлэх ажлыг мэргэжлийн түвшинд хийнэ.

4.3.4. “Ногоон хэрэм” төсөл хэрэгжүүлж, уул уурхай, газар тариалан, дэд бүтцийн байгууламж, бэлчээр ашиглалтын улмаас эвдрэл, доройтолд орсон газрыг нөхөн сэргээж дахин ашиглах боломжтой болгоно.

4.3.5. Сум суурин газрын ногоон байгууламжийн эзлэх талбайн хэмжээг 15 хувьд хүргэнэ.

4.3.6. Аймгийн төв, зарим эрсдэл бүхий сумын төвүүдийн үерийн хамгаалалтын далан, суваг, инженерийн барилга байгууламжийг хийнэ.

4.3.7. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлнэ.



23171  
СНОА0041

- 4.3.8. Бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт мэрэгч амьтадтай байгаль орчинд халгүй аргаар тэмцэж, холбогдох хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- 4.3.9. Бэлчээрийн доройтлыг бууруулах газар зохион байгуулалтын тогтолцоо бүрдүүлж, зохистой ашиглан хамгаалж, нөхөн сэргээх “Малчдын дундын сан”-г сум бүрд бий болгоно.

#### 4.4. Сэргээгдэх эрчим хүч

- 4.4.1. Сэргээгдэх эрчим хүчний ашиглалтыг нэмэгдүүлж, хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах хаягдлыг багасгах ногоон үйлдвэрлэлийн төсөл, хөтөлбөрүүдийг дэмжинэ.
- 4.4.2. Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай үйлдвэрлэл, хэрэглээг хөгжүүлнэ.
- 4.4.3. Эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт технологи ашиглан барилгын дулааны алдагдлыг бууруулна.

#### 4.5. Ногоон эдийн засаг – Эко хот

- 4.5.1. Ногоон эдийн засгийг дэмжих санхүүжилт, татвар, зээл, урамшууллын оновчтой хөшүүргийг бий болгож, эко технологийг дэмжих хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- 4.5.2. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг боловсронгуй болгож, байгальд халгүйгээр хадгалах, савлах технологийг дэмжинэ.
- 4.5.3. Тогтвортой ногоон хот, ногоон барилга, амьдралын ногоон хэв маяг, нөөцийн хэмнэлт зэрэг байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадлыг дэмжин хөгжүүлнэ.
- 4.5.4. Байгаль орчинд ээлтэй нийтийн тээврийн төрөл, үйлчилгээг хөгжүүлж, иргэд тав тухтай зорчих орчныг бүрдүүлнэ.
- 4.5.5. Явган зорчигчийн аюулгүй байдлыг хангасан зорчих хэсгийг нэмэгдүүлнэ.
- 4.5.6. Аймгийн 5 бүсэд экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бий болгоно.

### ТАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

#### 5.1. Бүс, орон нутгийн хөгжил

- 5.1.1. Бий болсон бүтээн байгуулалт, хөгжлийн хөтөлбөрүүдийн цаашдын хөгжил, ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, бүртгэл хяналтыг нэмэгдүүлж, салбар хоорондын уялдааг ханган ажиллана.
- 5.1.2. Аймгийн төв, Бэрх, Бор-Өндөр сумыг орон нутгийн зэрэглэлтэй хот болгож, бие даан хөгжих боломжийг бүрдүүлнэ.
- 5.1.3. Бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулан татварын тогтолцоог хөгжүүлж, алслагдсан бүс нутаг, аймаг, сумдад томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг бодлогоор дэмжинэ.
- 5.1.4. Хөдөө орон нутагт бизнес эрхлэгчдийг төрийн бодлогоор дэмжин ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 5.1.5. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.
- 5.1.6. Суурин газруудад байгаа хуучирч муудсан, эзэн эзэмшил, цаашид хэрхэх нь тодорхойгүй, иргэд олон нийтийн аюулгүй амгалан байдалд сөргөөр нөлөөлөхүйц барилга байгууламжийн эздийг тогтоон нэг мөр цэгцлэх, газрыг чөлөөлүүлэх, буулгах, шинээр бүтээн босгож эдийн засаг, нийгмийн эргэлтэд оруулна.
- 5.1.7. Нээлттэй хорих 419 дүгээр ангийг аймгийн төвөөс гаргаж шинээр барих, байгуулах асуудлыг төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлнэ.
- 5.1.8. Тендер хөрөнгө оруулалтын төсөв, шалгаруулалтыг ил тод нээлттэй зохион байгуулах, асуудал маргаангүй шийдвэрлэх бүх боломжийг бий болгох, хариуцлагажуулна.



5.1.9. Хөдөө, орон нутагт байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж агаар, хөрс болон орчны бохирдолгүй болно.

5.1.10. Орон нутагт ажиллах багш, эмч, төрийн албан хаагчдыг орон байраар хангах цогц арга хэмжээг төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд авч хэрэгжүүлнэ.

5.1.11. Аймгуудын шөнийн эрчим хүчний тарифыг тэглэнэ.

5.1.12. ХБУ-ны отрын бүс нутгийг чөлөөлөх асуудлыг УИХ, ЗГ-аар шийдвэрлүүлж, нутаг дэвсгэрийг Цэнхэрмандал, Жаргалтхаан, Дэлгэрхаан суманд шилжүүлнэ.

## 5.2. Хот хөдөөгийн тэнцвэртэй хөгжил

5.2.1. Экспортын чиглэлтэй үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлыг эрчимжүүлж, татварын болон эрх зүйн таатай орчин бүрдүүлнэ.

5.2.2. Жижиг, дунд үйлдвэрүүдийн цахим худалдааг дэмжих дэд бүтцийг бий болгон бизнес эрхлэх нэн таатай орчинг бий болгоно.

5.2.3. Улсын чанартай зам дагуу худалдаа, үйлчилгээний төв байгуулж, орон нутгийн бүтээгдэхүүнийг борлуулах боломжийг бүрдүүлнэ.

5.2.4. Аймгийн төвд болон Бэрх хотод барих дулааны станцыг ашиглалтад оруулна.

5.2.5. Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг дуусгана.

5.2.6. “Сумын хөгжил” хөтөлбөр хэрэгжүүлж, жишиг сумдын тоо, хөрөнгө оруулалтыг үе шаттай нэмэгдүүлнэ.

5.2.7. Сумдад халуун усны газрыг шинээр барьж, засвар үйлчилгээ хийж, нийтийн ахуйн үйлчилгээний дэд бүтцийг сайжруулна.

5.2.8. Хурх, ХБУ тосгодыг шилэн кабельд шат дараатай холбоно.

5.2.9. Аймгийн төвийн цэвэр усны насос станцын шугам сүлжээг өргөтгөж, хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

5.2.10. Хэрлэн сумын гэр хорооллын айл өрхийг усан хангамж, дулааны эх үүсвэрт холбоно.

5.2.11. Төв коллекторыг ашиглалтад оруулна.

5.2.12. Аймгийн төв болон зарим сумын цэвэр усны худгийг СМАРТ картын системд үе шаттайгаар шийдвэрлэнэ.

5.2.13. Жишиг гудамж төслийг аймаг, сумдын төвийн багуудад үе шаттайгаар бүрэн нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.

5.2.14. Орон нутгийн зорчигч тээврийн үйлчилгээг хэвийн болгоно.

5.2.15. Бор-Өндөр сумын инженерийн шугам сүлжээний шинэчлэлтийг хийнэ.

5.2.16. Зарим сумдын Засаг даргын Тамгын газрын барилгыг шинээр барина.

## 5.3. Эдийн засгийн бүсчилсэн хөгжил

5.3.1. Бүсүүдэд ХАА-н тээвэр логистикийн төвийг байгуулж, бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлж, хүнс, хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж дотоодын хэрэгцээг бүрэн ханган, экспортолно.

5.3.2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тодорхой хувийг тухайн суманд төвлөрүүлнэ.

